



ЧИГЛЭЛ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ц.БУМЦЭНД ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, И-мэйл: letter@moe.gov.mn
Вэб сайт: moe.gov.mn

2024.12.09 № 2/2590

танай _____-ны № _____-т

Тодруулгад хариу хүргүүлэх тухай

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас зарласан ТББЗСДТ/20240102005 дугаартай төслийн 45 сургуулийн гал тогоонд шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгсэл худалдан авах, нийлүүлэх (угсралт, суурилуулалт, хүргэлт, сургалт) тендерийн баримт бичигт танай байгууллагаас 2024 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 24/119 дугаартай албан бичгээр ирүүлсэн тодруулгад хариу хүргүүлж байна.

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, Сангийн яам, Хүүхдийг Ивээх сан хооронд Боловсролын Дэлхийн Түншлэл (GPE) байгууллагын буцалтгүй тусламжийн санхүүжилтийн гэрээг 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан. Буцалтгүй тусламжийн санхүүжилтийн гэрээний 2.1.1-т Appendix 1 /хавсралт-1/ - Program Implementation Manual /Хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарын авлага/-ыг баталгаажуулсан. Хөтөлбөр хэрэгжүүлэх гарын авлага нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд гэрээтэй нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хөтөлбөр хэрэгжүүлэх гарын авлагын 36-д "Энэхүү төслийн нээлттэй тендерийн худалдан авалтын багцад хүүхдийн хөгжлийг дэмжих танхимд зориулсан төхөөрөмж, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, сургуулийн үдийн хоол тэжээлийн тоног төхөөрөмж, холимог сургалтын мэдээлэл харилцаа холбоо технологийн тоног төхөөрөмж худалдан авах зэрэг багтана. Энэхүү төслийн хүрээнд Тендерийн баримт бичигт болон өрсөлдөөнт тендер дотоодын давуу эрх олгохгүй." гэж заасан.

Иймд Боловсролын яамнаас зарласан ТББЗСДТ/20240102005 дугаартай тендерийн баримт бичгийн ТШЗ 1.3-т дотоодын давуу эрх тооцохгүй гэж заасан.

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн Program Implementation Manual /Хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарын авлага/-тай танилцах нь нээлттэй бөгөөд тендерийн баримт бичгийн ТШЗ 8.1-д хаяг бичигдсэн байгаа болно.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Х.БАТЖАРГАЛ



14249 1940